

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2011-04-29/**

Ажлын хэсгийн хуралдаан 2011 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 14 цаг 30 минутад Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ажлын хэсгийн ахлагч, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгор, Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Ж.Ивээлэн, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын мэргэжилтэн Б.Батбаяр, Газрын тосны газрын хөрөнгө оруулалтын хяналтын тасгийн дарга Э.Оюун, Үндэсний татварын ерөнхий газрын улсын төсвийн орлого хяналтын газрын эрдэс баялгийн татварын хэлтсийн ахлах байцаагч Т.Цэцэгням, байцаагч Ч.Оюунчимэг, Ашигт малтмалын газрын уул уурхайн судалгааны хэлтсийн статистик мэдээлэл, судалгааны тасгийн мэргэжилтэн Б.Сүхтулга, мэргэжилтэн Б.Цэгц, Бороо гоулд ХХК-ийн санхүү эрхэлсэн дэд захирал Дог Кран, татварын нягтлан бодогч Г.Лхагва-Очир, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн захирлын зөвлөх Б.Эрдэнэдорж, Монголпросцветмет ХХК-ийн ерөнхий нябо Д.Номинзул, Инфорум төвийн тэргүүн А.Батпүрэв, Ил тод сангийн тэргүүн Д.Цэрэнжав, Миний монголын газар шороо хөдөлгөөний тэргүүн Б.Болдбаатар, Монголын байгаль орчны ТББ-уудын холбооны ерөнхийлөгч Б.Батболд, Нуурс ассоциацийн менежер Э.Сарангэрэл, Нээлттэй нийгэм форумын ажилтан Б.Алтанчимэг, Засгийн газрын ахлах референт, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 25 гишүүнээс 16 гишүүн оролцож ирц 64 хувьтай байв.

Мөн хуралдаанд нийслэлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Адьяа, Цөмийн энергийн газрын мэргэжилтэн Б.Наранцацral, Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав, ахлах аудитор Н.Эрдэнэцог, ахлах аудитор Б.Мэндбаяр, аудитор Ч.Номинчулуун, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар оролцов.

Ажлын хэсгийн хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор нээж, Сайн байцгаанаа уу! Өнөөдрийн ажлын хэсгийн хуралдаанаар бид 4 асуудал хэлэлцэнэ. Нэгдүгээрт, Монгол Улсын ОҮИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлангийн явц, урьдчилсан дүгнэлтүүд, хоёрдугаарт, 2009 оны нэгдсэн тайлангийн явцын талаар Ажлын албаны дүгнэлт, гуравдугаарт, 2011 оны 3 дугаар сард БНФУ-ын Парис хотноо зохиогдсон олон улсын бага хуралд оролцсон тухай танилцуулга, дөрөвдүгээрт, Монгол Улсын ОҮИТБС-ын 2010 оны нэгдсэн тайлан гаргах ажлын эхлэлийн явц, аудитын консорциумыг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах, бүрэлдэхүүнийг батлах гэсэн асуудлуудыг авч хэлэлцэнэ. Дараа нь хурлын дотоод журмын төслийг танилцуулж, хуралдаанаар хэлэлцэх асуудал, дотоод журмын талаар гишүүдийн зөвшөөрлийг авснаар хуралдааныг эхлүүлэв.

ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлангийн явц, урьдчилсан дүгнэлтүүд

Танилцуулгын эхэнд Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав хэлэхдээ эрхэм ажлын хэсгийн гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Манай Англи улсын Харт Норс групп, Монгол

Улсын Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хамтарсан консорциум нь Монгол Улсын ОҮИТБС-ын 2009 оны тайлангийн нэгтгэлд аудит хийж, өнөөдөр та бүхэнд ажлаа тайлагнах гэж байгаадаа баяртай байна. Энэ удаагийн аудитын нэгтгэлийн хүрээнд бид 20 аймаг, 121 сум, 101 уул уурхайн компаниуд, Засгийн газрын 24 байгууллага, төсвийн 26 байгууллага гээд нийт 290 гаруй байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй харьцаж энэ үйл ажиллагааг хийж гүйцэтгэлээ. Аудитын багийг Харт Норс группийн ерөнхийлөгч Тропер Крис болон Улаанбаатар аудит корпорациас ахлах аудитор Н.Эрдэнэцог нар ахалж 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2 сарын хугацаанд нэгтгэлийн ажлыг хийж гүйцэтгэв. Аудитын нэгтгэлийн ажлын урьдчилсан дүгнэлтийн талаар ахлах аудитор Н.Эрдэнэцог та бүхэнд дэлгэрэнгүй танилцуулга хийнэ.

Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ахлах аудитор Н.Эрдэнэцог олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2009 оны нэгдсэн тайлангийн явцын талаар товч танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Долгор: За баярлалаа. Ажлын албаны дүгнэлттэй танилцсаны дараа асуултаа асуугаад, саналаа хэлээд явья.

ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлангийн явцын талаар ажлын албаны дүгнэлт -Монгол Улсын ОҮИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлангийн талаарх ажлын албаны дүгнэлтийг зохицуулагч Ш.Цолмон танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав./

Б.Долгор: За асуух асуулт байна уу?

А.Батпүрэв: 2 асуулт байна. Нэгдүгээрт, Оюу толгойн бондтой холбоотой. Тайланг уншихаар Засгийн газар нь бондын орлогыг буцаагаад хүүтэй нь төлөх учраас орлого гэж тайлагнах шаардлагагүй гэсэн байна. Гэтэл Оюу толгой компани нь тухайн орлогыг эргүүлж авахгүй гэж тайлбар өгсөн гэж байна. Тэгэхээр энэ бондын орлогыг Засгийн газар төлөх юмуу, төлөхгүй юмуу? Энэ ямар учиртай вэ? Яагаад хоёр тал хоёр өөрөөр тайлбарлаад байна вэ? Хоёрдугаарт, ер нь та бүхэн аудитын мэргэжлийн хүмүүс учир асуух гэж байгаа юм. Манай энэ санаачлага нь тайлан гаргаад түүний мөрөөр мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах зорилго агуулаагүй. Гэхдээ компаниуд удаа дараа тодорхой баримттайгаар төрийн болон орон нутгийн байгууллагад хандив өгсөн гэж нотлоод, тэр нь тухайн хандив хүлээн авсан байгууллагын дансанд ороогүй, эсхүл Татварын ерөнхий газар юмуу, Сангийн яаманд мэдээлэгдээгүй хашаа ч юм алга болчихсон, магадгүй авилгын асуудал байгаа байх. Тэгэхээр энэ тохиолдолд манай энэ санаачлагын хүрээнд бус Монгол Улсын бусад хууль тогтоомжийн дагуу тухайлбал нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, аль эсхүл Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын хуулийн хүрээнд ч юмуу хариуцлага тооцдог, арга хэмжээ авах ямар боломжууд байна вэ?

Н.Эрдэнэцог: Нэгдүгээр асуултад хариулая. Оюутолгой болон Сангийн яамны байр суурийг танилцуулга дээр дурьдсан. Оюутолгой компанийтай бид хэд хэдэн удаа холбогдож, тодруулга авахад ер нь бид тэр бондын орлогыг буцаан авахгүй байх, янз бүрийн татвар, төлбөр, хураамжид суутгах байдлаар ч юмуу, ерөнхий чиг хандлага бол буцаан авахгүй гэж үзэж байгаа гэсэн тайлбарыг өгч байсан. Хэрэв буцаан авахгүй гэсэн байр суурьтай байгаа бол энэ нь Засгийн

газрын орлого болох ёстой гэж бид үзэж байгаа. Тэгэхээр бид үүнийг тайландаа оруулах юмуу, аль эсхүл хасах юмуу гэдгээ шийдэх хэрэгтэй байгаа. Хандив тусlamжийн тухайд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулиар ялангуяа, төрийн байгууллагууд хандив тусlamжийг заавал тайландаа оруулж тусгаж байх ёстой. Тэгээд энэ нь төрийн сангаар дамжаад Засгийн газрын нэгдсэн тайланд тайлагнагдаад явах ёстой. Зөрүү үүсээд байгаа гол шалтгаан бол ажиглаад байхад аливаа нэг орон нутгийн байгууллага хандив тусlamж аваадхаа ихэвчлэн гол ус, уул овоо тахих гэх зэрэг арга хэмжээнд зориулж аваад түүнийгээ зарцуулчихсан байдаг. Гэтэл үүнийгээ Засгийн газарт оруулах тайланд тусгадаггүйгээс зөрүү үүсдэг. Тэгэхээр зарим хуулийн зүйл заалт мөрдөгдөхгүй байна л гэсэн үг. Үүн дээр Сангийн яам илүү тайлбар өгөх байх аа.

А.Батпүрэв: Миний асуулт бол зөвхөн хандив тусlamжийн тухайд бус татвар, төлбөрүүд дээр хүртэл компани төлсөн гэж байхад орон нутгийн байгууллага хүлээж аваагүй, аль эсхүл Татварын ерөнхий газар, Сангийн яамны нэгтгэлд ороогүй алга болсон байх жишээтэй. Тэгэхээр ийм татвар, төлбөр алга болсон тохиолдолд манай санаачлагын хүрээнд бус, бусад санхүүгийн тухай хууль, тогтоомжийн хүрээнд ямар хариуцлага тооцох боломж байна вэ, ямар гарц байна вэ гэж асуусан юм.

Н.Эрдэнэцог: Нарийн судлаад үзэхээр татвар хурааж буй субъект нь өөр хүмүүс байдаг тохиолдолд, тухайлбал байгаль орчны байцаагч, эсхүл хорооны байцаагч татвар хураах тохиолдолд тэдгээр хүмүүсийн хоорондын ажлын уялдаа холбоогүйгээс Татварын ерөнхий газрын тайланд ордоггүй, ингээд зөрүү үүсээд байдаг. Энэ талаар Оюунчимэг сайн мэдэж байгаа байх, бид нар энэ талаар хоорондоо сайн ярилцаж байгаа. Тэгэхээр бид ийм зөрүүг яаж залруулж байна гэхээр эргээд тухайн аймаг, сумдын Засаг даргын Тамгын газартай харьцан албан ёсны баримтуудыг авч байж зөрүүг залруулж байгаа. Ер нь бол энэ асуудлыг нэг сайн цэгцлэх шаардлагатай байгаа юм. Ерөөсөө л орон нутагт төлөгдөж буй бүх л татвар, төлбөр, хураамж, хандив тусlamж нь Татварын ерөнхий газрын мэдээллийн баазад мэдээлэгдэж, нэгтгэгдэж байх гэсэн журмаа мөрдөх юм бол зөрүү үүсээд байх нь гайгүй гэж бодож байна.

Э.Сумьяа: За Батпүрэвийн нэгдүгээр асуултад тайлбар өгөхөд тэр Оюу толгойн 100 сая ам.долларыг тайлагнасан нь их зөв хэрэг болсон, цаашдаа ч бид ийм төлбөрүүдийг тайлагнуулна, эргэлзэх зүйл байхгүй. Цаашдаа ч Таван толгойн гэрээтэй холбоотойгоор ийм төлбөрүүд гарч ирнэ. Тэгэхээр Засгийн газрын 2009 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн хуралдаанд Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг мэдээлэл хийсэн байдаг: Түүнд “Монгол Улсын Засгийн газар, Айвенхоу майнз монголиа инк ХХК, Эрдэнэс МГЛ ХХК-ийн хооронд 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан Засгийн газрын өрийн бичиг худалдан авах тухай гэрээнд заасны дагуу Айвенхоу майнз монголиа инк ХХК нь 100 сая ам.долларыг Монгол Улсын тусгай дансанд 2009 оны 10 сарын 19-ны өдөр төвлөрүүлсэн тухай Монгол Улсын тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг Засгийн газрын гишүүдэд мэдээлэв.” гэжээ. Албан ёсны баримт нь энэ байна. Би яагаад үүнийг архиваас шүүлгэн олж авав гэхээр Сангийн яам Засгийн газрын өрийн бичиг худалдан авах тухай гэрээ хийгээд тайлбараа өгөхдөө “бонд” гэж өгсөн байгаа юм. Тэгэхээр үнэт цаас гэдэг утгаараа адилхан боловч, төрөл нь бол өөр байгаа. Энэ бол өрийн бичиг гэж байгаа учраас тайлбар нь өөр байна байх, санхүүгийн ажилтнууд тайлбарлаад бичнэ биз ээ. Үүнийг бид ойлгох хэрэгтэй.

Цаашдаа бид үүнийг тайлагнаж байна. Гэхдээ санхүүгийн данс бүртгэлийн хувьд олон улсын нягтлан бодох бүртгэлийн дагуу хийгдээд явах ёстой байх. Үүнийг бид хасья ч гэх юм байхгүй, тайлагнагдаж явна шүү.

За хоёрдугаар асуултын тухайд мөрдөн шалгах эрхгүй ч гэсэн зөрүү гарвал шалгах шаардлагатай бол манай гурван талаас хүн оролцуулаад шалгана шүү. Хуучин бид энэ шалгах үйл ажиллагааг санхүүжүүлэх мөнгөгүй байсан бол, одоо төсвөөс тодорхой хэмжээний санхүүжилт авч байгаа. Ер нь бол Засгийн газрын талд дутаад байгаа бол Сангийн яам шалгах эрхтэй. Харин Засгийн газрын ажилтан компани дээр очоод шалгахад хэцүү. Гурван талын оролцоо гурвуулаа байгаа учраас сум, орон нутагт өгсөн томоохон хандив, төлбөрийн зөрүүг бид нар шалгаж болно. Сангийн сайд, Татварын ерөнхий газрын даргын хамтарсан удирдамж батлуулаад шалгалтыг явуулж болно. Хэрэв компани дээр шалгалт хийнэ гэвэл Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдаар удирдамж батлуулаад ч явж болно. Энэ бол эрх зүйн үндэслэлтэй. Уул уурхайн ассоциацийн гишүүн байгууллага бол ассоциацитай хамтраад удирдамжаа батлуулж болно. Өөрөөр хэлбэл бид нар арга замаа зөв олох юм бол шалгалт хийх ямар нэгэн эрх хэмжээ бий. Ганцхан бидэнд арга хэмжээ авах эрх байхгүй. Баримтаар зөрүүгийн учир шалтгаан олдохгүй байвал хуулийн байгууллагад өгчих эрх байгаа. Иргэний нийгмийнхэн та бүхэнд шүүмжлэх ч эрх бас бий.

А.Батпүрэв: Миний тавьж буй санал бол ажлын хэсгээс бид нар очоод арга хэмжээ авах, мөрдөн шалгая гэсэн юм байхгүй, мөрдөн шалгах статус ч бидэнд байхгүй, байх ч шаардлагагүй. Засгийн газрын тайланда орох ёстой мөнгө төгрөг тайлагнагдаагүй байна, тэр нь ажлын хариуцлага, уялдаа холбоо янз бүрийн шалтгаантай байх. Магадгүй авилгын асуудал ч байгаа байх. Энэ санаачлагын гарч буй үр дүн нь өөрөө аль аль талаасаа өгсөн, авснаа тайлагнах, таарч байна уу, таарахгүй байна уу, хаана ямар асуудал байна, ил тод тунгалаг байх, ямар нэгэн хардлага, сэрглэг, үл ойлголцол байлгахгүйн төлөө л энэ санаачлагын ажлууд явж байгаа. Тэгээд хэдэн жил энэ тайланг гаргалаа, байнгын тодорхой хэмжээний зөрүүнүүд гарч байна, зөрүүнүүдийн учир шалтгааныг аудиторууд тайлбарлаж байна. Тэгэхээр орж ирэх ёстой мөнгө орохгүй байна, Засгийн газрын зүгээс өөрийн шугамаар яагаад энэ талаар засч залруулах арга хэмжээ авахгүй байна вэ, энэ санаачлагын хүрээнд бус Сангийн яам яагаад өөрийнхөө шугамаар арга хэмжээ авч болохгүй гэж гэсэн санааг хэлж байгаа юм.

Б.Осоргарав: Аудит хийж буй байгууллагын зүгээс, мөн ажлын хэсгийн зүгээс зөрүүг шалгах, нягтлах, арга хэмжээ авах эрх зүйн акт байхгүй байгаа юм. Түүнээс Монгол Улсын хувьд Сангийн яам, Татварын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар гэх зэрэг эрх бүхий газрууд хамтраад бид нарын энэ илрүүлсэн зөрүүг хянах, шалгах, цаашлаад арга хэмжээ авах бүрэн эрхтэй. Үүнийг бид цааш цаашдаа анхаарах хэрэгтэй байгаа юм. Бидний энэ нэгтгэх үйл ажиллагаа улам сайжраад явж байна гэж ойлгож байгаа, ноднин жил их хэцүү байсан, тэрний өмнөх жил бүр хэцүү байсан, энэ жил бол бид харьцангуй юмныхаа учрыг олчихсон, аль аль талдаа туршлагатай болчихсон сайжраад явж байна. Харин одоо энэ олж илрүүлсэн зөрүүг хууль хяналтын байгууллагатай хамтраад яаж хянаж шийдвэрлэх вэ гэдгээ ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн хурлуудаасаа шийдвэрлүүлээд зохих арга хэмжээ аваад явах нь зүйтэй. Үнэхээр энэ жил бид түрүү жилийн нэгтгэлтэй адил хугацаанд нэг дахин илүү ажлыг хийж гүйцэтгэх гэж нилээд их хүчин чармайлт гаргалаа. Үүнийг маань ойлгож үнэлж

ажлын албаны Цолмон гуай талархал илэрхийлсэн явдалд бидний хувь баярлаж байна. Монгол Улсын ОҮИТБС-ын 2009 оны тайланг 2 сарын хугац 260 гаруй байгууллагуудтай харьцаж, 265 тэрбум төгрөгийн анхны зөвтодруулж, 337 сая төгрөгийн шийдвэрлэгдээгүй зөрүүтэй байж болохоор ажил байна. 2008 оны нэгтгэл тайланда 46 компаниар нэгтгэхэд 400 гаруй сая төгрөгийн зөрүү үлдэж байсан. Бид 2009 оны нэгтгэл тайлангийн нийт шийдвэрлэгдээ зөрүүнээс 2,1 тэрбум төгрөгийн зөрүүг нь одоо аймаг, сум, компаниудаас ир нэгтгэж амжаагүй байгаа баримт дээрээ үндэслээд энэ ажлын хэсгээс гарч зөвлөмж, шийдвэрийн дагуу дахин тодруулга хийж, Үндэсний зөвлөлийн хуратанилцуулахаас өмнө шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Б.Долгор: За өөр асууж, тодруулах зүйл байна уу?

Д.Цэрэнжав: Хавсралт Б-д компаниудын оролцооны хүснэгт гэж гаргаса байна. Тэгэхээр энэ үнэлгээг манай энэ санаачлагын үйл ажиллагааны нөлөөллийн хэрэгсэл болгож ашиглах санаа оноо байгаа юу гэж Цолмонгоос асуумаар байна. Аудитын компани маань зовлон жаргалаа ярьлаа, оролцоотой холбоотой хүндрэлтэй асуудлууд байдаг юм байна. Тэгэхээр нэгэнт ингээд оролцооны үнэлгээ гэж гаргаж байгаа юм бол, үүнийг нэг ангилаад сайн оролцож байгааг нь, муу оролцож байгааг нь цохон тэмдэглээд нөлөөллийн хэрэгсэл болгон ашиглах боломж харагдаад байна. 2009 оны тайлан маань 4 дэх удаагийн тайлан болж гарч байна, урд жилүүдэд ийм оролцооны үнэлгээг гаргаж байсныг бол санахгүй байна, гэхдээ цаашдаа гаргаад явбал жил жилээр яаж өөрчлөгджэх байгааг нь харуулаад явбал нөлөөллийн механизмыг болж чадмаар юм шиг харагдаад байна. Мэдээж компанийн төлдөг татвар, төлбөрийн хэмжээгээс хамаарах байх, түүнийг харгалзан үзэх хэрэгтэй байх. Хоёрдугаарт, хандив тусламж авчихаад тайлагнадаггүй орон нутгийн Засаг даргын Тамгын газар их байдаг юм байна. Эд нарыг ч гэсэн жагсаагаад нөлөөллийн механизмыг болгон ашиглах нь зүйтэй болов уу. Түүнээс биш жилээс жилд сонирхолтой жишээ шиг л хандив тусламж авсан гээд л яваад байдаг, ямар ч хариуцлага хүлээлгэдэггүй ийм байдал ажиглагдаад байх юм.

Ш.Цолмон: Энэ бол их зөв зүйтэй санал. Манай аудиторууд ажлын удирдамжийн дагуу оролцоог дүгнэсэн ийм хүснэгт гаргадаг. Ажлын албаны зүгээс бас зарим нэг тоон судалгаа хийсэн. Тухайлбал 2006 оноос хойш 5 удаагийн тайлан гаргах явцад давтагдсан тоогоор 668 компани тайлан гаргасан байдаг, үүнээс жил бүр тайлан гаргасан буюу нийт 5 удаагийн тайлан гаргасан 23 компани байна. Үүнийг бид Үндэсний зөвлөлийн хурлаар аудитын нэгтгэлийн тайлантай хамтатгаад танилцуулж гэж бэлдсэн. Тэгэхээр иймэрхүү судалгаа бол их чухал юм. Цэрэнжав гуайн саналыг бүрэн дэмжиж байна, та бүхэнтэй хамтран ажиллахад бэлэн байна.

Б.Долгор: Өөр тодруулах зүйл байна уу?

Э.Сумъяа: За бидэнд хүргүүлсэн тайланг уншаад төлбөрийн зөрүү гээд нилээд асуулт бэлдсэн байсан. Гэтэл аудиторууд маань тодруулах боломжтой болсон гээд шийдвэрлэгдээгүй зөрүүг 337 сая төгрөг гэж танилцууллаа. Тэгэхээр одоо 337 сая төгрөг нь цөөхөн хэдэн төрлүүд дээр үлдэж байна. Тухайлбал үл хөдлөх өрөнгийн албан татвар дээр 17 сая төгрөг, ус рашаан ашигласны төлбөр дээр 40 сая төгрөг, зохих хууль тогтоомжийн дагуу төв орон нутгийн төрийн захиргааны

байгууллагад төлсөн тэмдэгтийн хураамж, бусад хураамж дээр 40 сая төгрөг, гаалийн үйлчилгээний хураамж 40 сая төгрөг, байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал гэдэгт 82 сая төгрөг, байгаль хамгаалах ажилд зарцуулсан зардал гэдэгт 97,8 сая төгрөг зэрэг зөвхөнүүд үлдсэн байна. Эдгээрийг та нар компаниар нь тодруулаад өгөх боломж байна уу? Төрийн захиргааны байгууллагуудын оролцоог зэрэглэсэн байсан, тэр чинь одоо дахиж өөрчлөгдөх үү? Өөр нэг асуулт бол аудитын цаашдын үйл ажиллагаатай холбоотой байгаа юм. Манай улс бол ганцаараа дотоодын аудитын компани, гадны аудитын компанийтай хамтарсан консорциумаар аудит хийлгэдэг. Бусад орнууд бол зөвхөн гадны компанийар хийлгүүлдэг. Тэгэхээр бид цаашдаа зөвхөн дотоодын компанийар аудит хийлгэх талаар Олон улсын удирдах хороо, баталгаажуулалтын хороонд санал тавьбал манай дотоодын аудитын компаниудад ийм боломж бололцоо, чадавхи байна уу? Түүнчлэн энэ 101 компани дотроос танайхаар санхүүгийн тайландаа аудит хийлгэсэн компани байна уу?

Б.Мэндбаяр: Нэгдүгээр асуултад хариулая. 337 сая төгрөгний шийдэгдээгүй зөрүү нь хэдхэн төрлийн татвар, төлбөр дээр байгаа юм. Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувьд Монголросцветмет, Монголын алт корпораци, Олон овоот гоулд, Поло ресорсиз гэсэн компаниуд дээр зөрүү үлдсэн, ус рашаан ашигласны төлбөрийн хувьд Өрмөн уул, Поло ресорсиз компаниуд дээр гарсан, газрын төлбөрийн зөрүү Хурай компани дээр гарсан, байгаль хамгаалах зардлын тухайд Шивээ овоо компанийн 18 сая төгрөгний зөрүү үлдсэн, ер нь байгаль хамгаалах зардлын тухайд компани талаасаа төлбөрөө нотолчихсон, харин БОАЖЯ-ны Байгалийн нөөцийн газар хариу ирүүлээгүйн улмаас нэг талын дүнгээр баталгаажуулж болохгүй тул энэ шийдэгдэхгүй үлдсэн байгаа, хураамж үйлчилгээний 40 сая нь авто тээврийн хураамж гэх зэрэг бага дүнтэй зөвхөнүүд маш олон компани дээр гарсантай холбоотой, харин 438 сая нь Оюу толгой, Чинхуа MAK нарийн сухайт, MAK зэрэг компаниуд дээр гарсан ба үүнийг Ашигт малтмалын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Авто тээврийн газраас хариу тодруулга авсны үндсэн дээр залруулах боломжтой гэж үзэж байгаа юм.

Б.Осоргарав: За Сумъяа гуайн гадны компанийтай хамтрахгүйгээр дангаар энэ аудитын нэгтгэлийн ажлыг хийж чадах уу гэсэн асуултад хариулахад бид чадна гэж хариулна. Учир нь бид энэ 2 удаагийн тайланг гаргах явцад их туршлага хуриатлууллаа. Манай компанийн хувьд бол дангаар хийж гүйцэтгэх бүрэн боломжтой гэж үзэж байна. Гуравдугаарт, энэ 101 компани дотор Эрдэнэт, Эмээлт майнз, Флинк монголиа, Вестерн проспектор гэх зэрэг 4-5 компани манай байгууллагаар санхүүгийн тайландаа аудит хийлгэсэн. Эдгээр компанийд дээр тэр хандив тусламжийн зөрүү гараагүй болно.

Б.Долгор: За өөр асуулт байна уу? Би нэг асуулт асууя. Төрийн байгууллагад үнэлгээ хийсэн байна. Жишээлбэл, муу гэдэг дээр БОАЖЯ орж байна, дунд гэдэгт СЯ, АМГ, ТӨХ орсон байна. Тэгэхээр эд нарт ямар учир шалтгаанаар ийм үнэлгээ тавьсан бэ? Энэ оролцоог нэмэгдүүлэхийн тулд цаашид ямар арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байгаа вэ?

Б.Мэндбаяр: БОАЖЯ-нд яагаад муу гэсэн үнэлгээ өгсөн гэхээр бид нар энэ ажлыг 2011 оны 2 дугаар сарын 14-ны өдрөөс эхэлсэн ба 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн албан газрууд, 101 компаниуддаа албан бичгийг хүргүүлсэн. Гэтэл

ОАЖЯ-ны Байгалийн нөөцийн газраас нилээд нэхүүлж байж 4 дүгээр сарын 8-ы өдөр хариуг ирүүлсэн. Нөгөө талаас жилийн жилд байгаль хамгаалахтай олбоотой зардал дээр нилээд өндөр зөрүү гардаг, үүнтэй холбоотойгоор 5ОАЖЯ нь жил бүр компаниас тайланг авахдаа санхүүгийн тайлантай нь уялдуулж үнэн зөв мэдээлэл авах тал дээр санаачлагагүй ажилладаг, анхаарал хандуулдаггүй гэдэг утгаар муу гэсэн үнэлгээг өгсөн. Төрийн өмчийн хорооны тухайд Засгийн газрын 2007 оны 80 дугаар тогтоолын дагуу санаачлагын тайланг гаргах чиг үүргийг зааж өгсөн байдаг боловч нэгтгэлийн тайланг гаргаж өгөхгүй байгаа. Сангийн яамны тухайд тайлангаа нэгтгэх, тодруулагад хариу өгөх ажиллагаанд нилээн цаг хугацаа авдаг. Ашигт малтмалын газрын тухайд 2009 онд аливаа төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр тооцох Монгол Улсын хууль гарсан байдаг, нөгөө талаар Ашигт малтмалын тухай хуульд нөөц ашигласны төлбөрийг амдоллараар хүлээж авах боловч тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцно гэсэн байдаг. Гэтэл ОҮИТБС-ын тайланг гаргахдаа амдоллараар нь гаргасны улмаас жил бүр зөрүү гардаг. Түүнчлэн лицензийн хөдөлгөөн дээр их зөрүү гардаг. Лицензээ худалдсан, шилжүүлсэн бүртгэл хөдөлгөөн хийгдэггүйн улмаас өмнөх компанийн нэр дээр төлбөр нь гардаг. Үүнээс болж зөрүү их үүсдэг. Энэ утгаараа Ашигт малтмалын газарт дунд гэсэн үнэлгээ тавьсан.

Б.Долгор: Өөр асуулттай хүн байна уу? За асуулт байхгүй бол санал хэлэх хүн байна уу?

Т.Цэцэгням: Тайланг уншиж үзлээ мөн асуусан асуултад хариулсан байдлыг сонсож үзээд 2 санал хэлэх байна. Ер нь аливаа судалгааг гаргахдаа заавал регистрийн дугаартай хийж баймаар байна. Яагаад гэвэл зарим компаниуд 2-3 охин компанийн байхад, тэгээд зарим төлбөрүүдээ нөгөө компанийн нэрээр төлсөн байх зэрэг шалтгаанаас зөрүү үүсдэг. Тиймээс маягт боловсруулахдаа регистрийн дугаарийг тавиад хэвшчихвэл зөрүү гарахгүй байх магадлал өндөр. Хоёрдугаарт, үл хөдлөх хөрөнгийн татварын зөрүү гарсан гэлээ. Ийм зөрүү гарах үндэслэл бол байхгүй. Тодруулга хийхдээ төлсөн баримтыг авахын хажуугаар орон нутагт тайлагнасан үл хөдлөх хөрөнгийн татварын тайланг нь хамт авах хэрэгтэй.

Э.Сумъяа: Өнөөдрийн ажлын хэсгийн хурал бол нилээн онцлог нөхцөлж болж байгаа. Нэгдүгээрт, бид Парисын бага хуралд оролцоод энэхүү санаачлагын дараагийн үе шатны бодлого, нэмэлт шаардлага, арга хэмжээ, үйл ажиллагас хэрэгжүүлэх нөхцөлд болж байгаа. Хоёрдугаарт, энэхүү 2009 оны тайлан нь Монгол Улс баталгаажуултад тэнцсэний дараагаар гаргаж буй тайлан гэдгээр онцлог. Гуравдугаарт, өнөөдрийн бүрэлдэхүүнд хүмүүс нилээн ажлын хэсгийн гишүүдийн оронд өөр хүмүүс ирсэн байна. Улсын Их Хурал Таван толгойн гэр одоо хэлэлцэж буйтай холбоотойгоор манай ажлын хэсгийн зарим гишүүд тухаралд оролцож байгаа. Ялангуяа Засгийн газрын байгууллагынхан. Тиймээс бүхэн өнөөдрийн хуралд танилцуулсан материалуудыг, энд гарч буй асууд ажлын хэсгийн жинхэнэ гишүүдэд сайн уламжилж өгөөрэй гэж хүсмээр байна.

Тайлантай холбогдуулаад хоёр гурван зүйл хэлэе. Нэгдүгээрт, үг үс алдаа байна шүү. Тухайлбал 14 дүгээр хуудсанд Ашигт малтмалын газар бичсэн байна, энэ бодвол Газрын тосны газар гэж байна байх. Түүнчлэн хам эхний нүүрэнд “ажлын хэсэг, үндэсний зөвлөлийн гишүүдийн хэрэгтэй

зориулав" гэж бичсэн нүүр цаашдаа хэрэггүй шүү. Одоо энэ тайланг нийтэд зориулж гаргаж байгаа. Явцын тайлан гэдэг утгаараа та бүхэн ингэж бичсэн байх, гэхдээ эцсийн тайланд энэ хэрэггүй шүү. Хоёрдугаарт, зарим юмыг цаг хугацааны хувьд харж тайландаа оруулж өгөөчээ гэж хүсэх гэж байна. Нэгдүгээрт материалаг төлбөрийн гээд 16 дугаар хуудсанд байж байгаа, энэ бол өнгөрсөн оны 6 сард Үндэсний зөвлөлийн хурлаас гарсан шийдвэр. Гэтэл тайлан маань 2009 оны 3 сараас хойш гарсан тайлан. Тиймээс үүнийг тайландаа тэмдэглэж өгөөчээ, учир нь тэр материаллаг төлбөрийн шийдвэрийг тайлантай харьцуулбал цаг хугацааны хувьд мөрдөж эхлээгүй байсан гэсэн үг. Хоёрдугаарт, хандив тусламжийг бүртгэх тухай Сангийн сайдын тушаал 3 дугаар сарын 1-нд гарсан. Тиймээс энэ цаг хугацааны нөхцөл байдлыг дурьдаж өгөөчээ гэж хүсэх байна.

Өөр нэг юм бол газрын тосны компаниудаас хүлээн авсан орлогын талаар Газрын тосны тайлан гаргаж өгсөн. Энэ их сайн юм болсон. Өмнө нь бид олборлолтын компаниудаас тайлан гаргуулж авдаг байсан бол 2010 оны тайлангаас эхлээд хайгуулын компаниуд бие даасан маягтаар тайлан гаргадаг болсон. Тиймээс үүнийг дурьдаж өгөөчээ. Газрын тосны маягт 3 дээр сургалтын төлбөр гэж оруулсан байдаг гэхдээ энэ нь хүмүүст зориулсан зардал байдаг. Үүнээс гадна Газрын тосны газрын ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэхэд зориулж ганц нэг компаниуд мөнгө гаргасан байна лээ, үүнийг анхаарч дурьдаж өгнө үү гэж хүсэж байна. Шийдвэрлэгдээгүй зөрүүний тухайд зарим компанийн нэр татвар, төлбөр гэсэн нэг төрөл дээр 2 удаа орсон байна, түүнийг цаашид анхаараарай, төлбөр дотор татвар гэсэн үг явж байна лээ эргэж эдгээрийг анхаараарай. Та бүхэн тодруулга дахиж хийх боллоо. Үүнийг тэмдэглэл дээрээ тодорхой оруулах байх.

Хоёр дахь тайланг хэлэлцэх явцад бид Үндэсний зөвлөлд оруулах шийдвэрийн төсөл бэлдэнэ. Ер нь бол жил болгоны нэгдсэн тайлан гарсны дараагаар бид Засгийн газрын юмуу Ерөнхий сайдын шийдвэр гаргаж явдаг. Тийм учраас та бүхэн зөвлөмж хэсгээ болж өгвөл надад эртхэн ажлын хэсгийн хурлаас өмнө ирүүлбэл сайн байна. Тэгэх юм бол би ажлын шугамаар Засгийн газрын байгууллагын гишүүдтэйгээ холбогдож байгаад шийдвэрийн төсөл бэлдэх төлөвлөгөөтэй байна. Мөн цаашид 80 дугаар тогтоолыг хүчингүй болгож түүнийг орлосон нэг том тогтоол гаргамаар байна. Ажлын хэсгийн гишүүд санал байвал надад өгөөчээ.

Улаанбаатар аудит корпорацид нэг санал тавих гэж байна. Та бүхэн тэр консорциум болж буй компанийтайгаа хамтраад гадны оронд аудит хийгээчээ. Монгол Улс цаашдаа заавал гадны компанийтай хамтарсан байдлаар бус дан дотоодын компани аудит хийх боломжтой гэж би үзэж байгаа юм. Үүний тулд манай дотоодын аудитын компани олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байх хэрэгтэй байна. Дотоодын компани дангаар гүйцэтгэхийн нэг ач холбогдол бол зардлын хувьд арай бага тусах байх. Мөн та бүхэн материаллаг төлбөр дээр санал хэлж байна, түүнийгээ томъёолоод өгөөчээ. Цолмон материаллаг төлбөрийн тухай шийдвэрээ аудиторууддаа өгөөрэй. Яг үнэндээ бид тэр материаллаг төлбөрийг тодорхойлоходоо хууль харж байгаад л хийсэн. Гэхдээ хуулийг хэрэглээгүй учир бид мэдэхгүй байна, тийм учраас та бүхэн мэргэжлийн гэдэг утгаараа саналаа өгөөчээ гэсэн саналтай байна.

Б.Долгор: За баярлалаа. Тэгэхээр байдлыг хараад байхад цаашдаа нилээн олон зүйл дээр анхаармаар, ялангуяа төрийн байгууллагуудын хувьд ажлын уялдаа холбоог сайтар хангамаар, ажлын чанар байдал, түрүүчийн дурьдсан тодорхой асуудлуудыг илүү тодруулах гэх зэрэг олон ажлууд хийх шаардлагатай нь харагдаж байна. Тухайлбал, Ашигт малтмалын газрын тухайд лицензийн шилжүүлэлт, бүртгэлийн асуудал, төлбөр тооцоог төгрөгт шилжүүлэн тайлагнах гэх зэрэг зарим хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд цаашлаад манай агентлагуудын хоорондын уялдаатай холбоотой, тайлагнах маягтууд нь нэг байхтай холбоотой, байгаль хамгаалах зардалтай холбоотой, ер нь байгаль хамгаалах ажлын гүйцэтгэл, тайлантай холбоотой олон асуудлууд байна. Тэгэхээр энэ асуудлууд дээр төрийн байгууллагынхаа түвшинд ажлын албаны зүгээс нөлөөлж ажиллах шаардлага байгаа нь харагдаж байна. Тэгэхээр энэ талаар Сумъяа гуай та ерөнхийд нь хариуцаад эдгээр нөхдүүдтэй ярьж байгаад саяны дурьдсан асуудлуудаа нэг мөр цэгцэлж авах шаардлагатай байна.

Түрүүнд Цэрэнжав гуай хэлж байсан, бид нар энэ тайланг яах гэж гаргаж байгаа юм бэ гэхээр их ойлгомжтой л доо. Энэ чиглэлийн ажлуудаа сайжруулах зорилгоор л гаргаж байгаа. Гурван тал гурвуулаа тайлан гаргахад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд цаашдаа ямар хэмжээний ололт, амжилт гарах ёстой вэ гэдэг дээр анхаарах ёстой. Тийм учраас ер нь тайланд сайн оролцож байгаа компаниуд, газруудыг зориуд дурьдаж урамшуулж байх нь зүйтэй. Нөгөө талаас тааруу оролцож буй, үл ойшоодог, тайлан гаргахад тодорхой хэмжээний зөрчил дутагдал байгаа гэдэг нь харагдаж байгаа тохиолдолд бид бас нөлөөллийн чиглэлийн ажлуудыг хийх ёстой, олон нийтэд мэдээлэх ажлыг ч хийх ёстой, шалгаж нягтлах чиглэлээр ч ажиллах ёстой гэдэг зүйл дээр санал бүрэн нийлж байна. Тэгэхээр энэ чиглэлийн асуудлуудыг анхаарая гэдгээ өнөөдрийн хурлын шийдвэртээ тусгаж өгье.

Тайлантай холбоотой асуудал дээр шийдвэрлэгдээгүй зөрүү бүрийг тал тус бүр дээр тодорхойлж өгмөөр байна. Компани бүр дээр, засгийн газрын байгууллагууд бүр дээр нягтлаад эцэслэн шийдвэрлэгдээгүй буюу шийдвэрлэж чадсан чадаагүй гэдгээр нь протокол байгуулж, баталгаажуулах хэрэгтэй байна. Үнэхээр шийдвэрлэгдэхгүй зөрүү байгаа бол түүний шалтгааныг дурьдаж өгөөд шийдвэрлэх ямар арга зам байгаа талаар санал зөвлөмж хэсэгтээ дурьдаж өгмөөр байна. Бид түүний мөрөөр ажиллах ёстой гэж үзэж байна. Шийдвэрлэгдээгүй зөрүү бүрийн шалтгаан, шийдвэрлэх санал зөвлөмжийг ажлын хэсгийн дараагийн хурлаар авч хэлэлцэе. Мөн Засгийн газрын байгууллагуудаар нэгтгэл хийх ажлыг дуусгаад тайландаа хавсаргаж өгөөчээ. Ингэх юм бол бид нарын эхэнд ярьсан цаашдын ажлыг сайжруулахад тустай.

Хоёрдугаарт манай ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж буй Засгийн газрын байгууллагын хүмүүс маань хариуцлагаа өндөржүүлэх хэрэгтэй байна. Ер нь бол биечлэн ирсэн хүмүүс ойлгож байгаа байх, харин төлөөлж ирсэн хүмүүс цааш ажлын хэсгийн гишүүдэд энэ асуудлыг дамжуулж хэлээрэй. Жишээлбэл, саяны тайланд дурьдаад байгаа, зөвлөмж болгоод байгаа цаашид энэ асуудлуудыг сайжруулая гэж санал болгоод байгаа энэ асуудал тус бүр дээр төрийн байгууллагууд өөрсдөө төрийн байгууллага тус бүр дээрээ ямар нэгэн хэмжээний санал боловсруулж ирэх үүрэг өгч байна. Ер нь дараагийн хуралдаан дээр энэ чиглэлээр юу хийсэн, ямар саналтай байгаа талаар төрийн байгууллагын төлөөлөгч бүрийн саналыг сонсоё. Ер нь хуралдаан бүр дээр ийм

мэдээлэл хийж байх нь зүйтэй гэсэн саналтай байна. Дашрамд дурьдахад иргэний нийгмийн байгууллагуудын хувьд ч гэсэн, компаниудын хувьд ч гэсэн өөрсдийн саналуудыг бэлтгэж ирмээр байна. Ялангуяа бид тайлан гаргах энэ ажлыг үр дүнтэй болгохын төлөө л санаачлагын ажлын хэсэг гэж байгаа. Тийм учраас зүгээр нэг хуралд суугаад яваад байх биш, ажлын хэсгийн гишигүүн гэдэг утгаараа санаачлагатай ажиллахыг зөвлөж байна.

За ийм зүйлүүдийг шийдвэртээ тусгаад явъя, өөр саналтай хүн байна уу?

Б.Осоргарав: Сумъяа гуай сайхан санал хэллээ. 80 дугаар тогтоолыг хүчингүй болгоод Засгийн газрын томоохон тогтоол гаргая гээд. Үүнтэй холбогдуулан санал хэлэхэд ОУИТБС-ын ажлын алба нь нэр томъёоны хувьд оноогүй юм болов уу, учир нь тодруулгын явцад ажлын албанаас ярьж байна гээд холбогдохоор уул уурхайн компаниуд тоохгүй байх жишээтэй, хүн хүчний хувьд ч гэсэн ажлын алба маань их дутмаг, цаашдаа өргөн хүрээнд санаачлагыг хэрэгжүүлээд явна гэхээр хүн хүч хүрэлцэхгүй, дутмаг юм шиг санагддаг. Тиймээс тэр 80 дугаар тогтоолын оронд гарах тогтоолын төсөл дээр ажлын албаны нэр томъёог өөрчлөх, бүтэц бүрэлдэхүүнийг нэмэх талаар анхаарч оруулах гэсэн саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1.Аудитын консерциумаас Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлангийн урьдчилсан дунг хэлэлцээд дэмжиж, тайланг эцсийн байдлаар гаргаж Ажлын хэсгийн дараагийн хуралдаанд танилцахаар тогтов. Тайланд дараахь асуудлыг тусгахыг зөвлөмж болгов:

-Шийдвэрлэгдээгүй зөрүү бүр дээр нэмэлт тодруулга хийж, учир шалгааныг компани, төрийн захиргааны байгууллага, аймаг, сум бүрээр гаргаж, зөрүүг хариуцагч бүртэй протокол байгуулж, баталгаажуулсан байх;

-Шийдэгдээгүй зөрүүг шийдвэрлэх боломжийн талаар санал зөвлөмжийг тодорхой оруулах;

-Гэрээнд заагдсаны дагуу Засгийн газрын байгууллагуудаар нэгтгэл хийх ажлыг дуусгаж, тайланд хавсаргасан байх;

-Тайлангийн англи хэл дээрх хувилбарыг бэлэн болгосон байх;

-Ажлын хэсгийн хуралдааны өмнө тайлангийн бүрдэл хэсэг гэрээнд заагдсаны дагуу бүрэн байгаа эсэх талаар ОУИТБС-ын Ажлын албатай тохирсон байх.

2.Монгол Улсын ОУИТБС-ын тайланг нэгтгэх, тодруулга, тулгалт хийх үйл ажиллагааны явцад төрийн байгууллагатай холбоотойгоор тулгамдаж буй асуудлуудыг нэг мөр цэгцлэх асуудлыг судалж, энэ чиглэлээр Засгийн газрын шийдвэрийн төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, ажлын хэсгийн хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нарт даалгав.

3.Тайлан гаргах үйл явцад идэхтэй оролцдог төрийн байгууллага, компаниудыг урамшуулах, тайлан бүрээр удаа дараалан зөрүү гарсан, ажилд хойрго ханддаг төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, компаниудын талаар олон нийтэд мэдээлж, нөлөөллийн чанартай үйл ажиллагаа явуулж байхыг Ажлын алба /Ш.Цолмонд/ -д даалгав.

4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа бүх гишүүд, ялангуяа Засгийн газрын байгууллагын гишүүд тайлантай холбоотой, тайлангаар гаргасан зөрүүтэй холбоотой асуудлыг байгууллагынхаа удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, энэ талаар дараагийн ажлын хэсгийн хуралдаанд мэдээлэхээр тогтов.

5. Цаашид ажлын хэсгийн хуралдаанд компани, иргэний нийгмийн төлөөлөн оролцож буй гишүүд ОУИТБС-ын тайлангийн үйл явцыг үр дүнтэй болгох чиглэлээр санал зөвлөмж боловсруулж, түүнийгээ танилцуулж хэвшүүлэхийг зөвлөмж болгов.

3.ХЭЛЭЛЦСЭН нь: 2011 оны 3 дугаар сард БНФУ-ын Парис хотноо зохиогдсон Олон улсын бага хуралд Монгол Улсын төлөөлөгчид оролцсон тухай танилцуулга

Б.Долгор энэ талаар Ш.Цолмон танилцуулна.

Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон Олон улсын 5 дугаар бага хуралд оролцсон тухай товч танилцуулга хийв. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Долгор: За баярлалаа. Манай улс ОУИТБС-ын Олон улсын Удирдах хорооны даргын нэрэмжит шагнал авсан явдал нь манай Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн гишүүд, ажлын албаны ажилтнууд, төлөөлөгчдийн идэвх чармайлт, хүчин зүтгэлтэй салшгүй холбоотой. Тэгэхээр та бүхэнд талархлаа илэрхийлэхийн ялдамд цаашдын ажилд амжилт хүсье. Энэ асуудалтай холбоотойгоор санал хэлэх хүн байна уу? За байхгүй бол дараагийн асуудалдаа орьё.

4. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ын 2010 оны нэгдсэн тайлан гаргах ажлын эхлэлийн явц, аудиторын консорциумыг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулах, бүрэлдэхүүнийг батлах тухай

Б.Долгор энэ асуудлыг Ш.Цолмон танилцуулна.

Ш.Цолмон: Саяхан 2010 оны нэгдсэн тайланг хийж гүйцэтгэх ажлын удирдамжийг ажлын хэсгийн гишүүдээс ажлын шугамаар хэд хэдэн удаа санал авч, батлуулсан болно. Улмаар өдөр тутмын сонин дээр 2011 оны 4 сарын 20-ны өдөр зар мэдээ тавьж, тендерийг албан ёсоор зарласан. Ажлын алба нь 2011 оны 5 сарын 20-ны өдөр хүртэл тайлан гаргахад оролцох сонирхлоо илэрхийлсэн бичиг баримтыг хүлээн авна. Тендерийг сонгон шалгаруулах техникийн бэлтгэл ажлууд хангагдсан, харин одоо энэхүү сонгон шалгаруулалтыг хийх үнэлгээний хороог дараахь бүрэлдэхүүнээр байгуулах саналтай байна. Үүнд үнэлгээний хорооны даргаар Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь, гишүүдэд Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Ж.Ивээлэн, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Монголросцветмет ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч Д.Номинзул, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон миний бие гээд нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй батлах саналтай байна. Тендерийн материал англи хэл дээр байдаг тул ерөнхийдөө англи хэлний мэдлэгтэй, санхүүгийн зохих мэдлэгтэй байх гэсэн шаардлага тавигдаж байгаа. Бүрэлдэхүүний талаар та бүхэнд санал байвал сонсоход бэлэн байна.

Б.Долгор: За бүрэлдэхүүний талаар санал байна уу?

А.Батпүрэв: Дорждарь, Алгаа гуай гээд нэгөө тогтсон хэдэн хүмүүс л үнэлгээний хороонд ажиллаад байна. Түрүү жил би Дорждарийн оронд үнэлгээний хороонд ажилласан. Өмнөх жилүүдэд аудитын компаниуд юу хийхээ мэддэггүй байсан бол, энэ удаа юу хийхээ мэддэг болчихсон, илүү туршлага хуримтлуулаад ирэхээр өрсөлдөөн илүү өндөр болох байх. Тэгэхээр энэ үед нэгөө хуучин хүмүүс л үнэлгээний хороонд ажиллаж байвал энэ нь жоохон хэл ам дагуулах, асуудал, гомдол гаргах магадлалтай юм шиг харагдаж байна. Миний хувьд эдгээр хүмүүс зайлшгүй байх шаардлагатай гэж үзвэл бүрэлдэхүүний тоог нэмэх, аль эсхүл эдгээр байгууллагуудаас оронд нь өөр ажилтанг томилох гэсэн саналтай байна.

Б.Долгор: Ер нь бол Ивээлэн, Номинзул хоёр шинээр бүрэлдэхүүнд орж байгаа. Дорждарийг миний хувьд маш туршлагатай учраас үнэлгээний хорооны дарга байх нь зүйтэй гэж үзэж байна. Харин Алгаа гуайг өөрчилж болох юм.

Б.Батболд: Хэрэв эдгээр хүмүүс нь зайлшгүй байх шаардлагатай гэж үзэж байгаа бол ил тод байх гэдэг утгаараа хүний тоог нь нэмээд 7 болгох гэсэн саналтай байна.

Б.Долгор: За болно болно. Тэгвэл нэмэлт 2 гишүүнээр хэнийг оруулах вэ?

Э.Сумъяа: Үнэлгээний хорооны бүрэлдэхүүний олонхи нь тендерийн мэргэшсэн үнэмлэхтэй хүн байх ёстой гэсэн шаардлага бий шүү. Өмнө нь бид Дэлхийн банкны сонгон шалгаруулалтын журмаар явж байсан, харин одоо Сангийн яамны тендерийн журмаар явна. Сангийн яамны журмаар 5 хүний 3 нь үнэмлэхтэй байх ёстой гэх зэрэг шаардлага тавигдана шүү. Тиймээс тендерийн үнэмлэхтэй гишүүнийг бүрэлдэхүүнд нэмж оруулая.

Б.Батболд: Үнэмлэхтэй байх ёстой гэхээр л хязгаарлаад ирж байгаа юм. Тэгэхээр тэр үнэмлэхийг яаж авах боломжтой талаар тайлбарлах, мэдээлэх хэрэгтэй шүү дээ. Хэрэв тэр боломжийг олгоод өгвөл бид Сангийн яамаар асуудлыг оруулаад тэр үнэмлэхийг авч болно шүү дээ.

Б.Цэгц: Монголросцветмет нь төрийн өмчийн оролцоотой компани тул цэвэр хувийн өмчит компаниас төлөөлөл оруулмаар байна, түүнчлэн иргэний нийгмийн төлөөллөөс оруулах хэрэгтэй болов уу гэсэн саналтай байна.

А.Батпүрэв: Бид иргэний нийгмийн ТАН эвсэл дотроосоо нэр дэвшүүлээд дотроосоо сонгоод оруулвал яаж байна?

Б.Долгор: Одоо бидэнд хүлээж суух цаг байхгүй. Тиймээс одоо энэ ажлын хэсгийн гишүүд дотроосоо сонгоод явъя.

Б.Батболд: Тайланг харж байхад байгаль орчинтой холбоотойгоор зөрүү их гардаг юм байна. Тэгэхээр би байгаль орчны ТББ-уудын эвсэлээ төлөөлөөд үнэлгээний хорооны гишүүнээр ороход татгалзах зүйл алга.

Г.Лхагваочир: Хувийн компанийн төлөөлөл болгоод Бороо гоулд ХХК-ийн татварын менежер Б.Ганхүлэг гуайг гишүүнээр оруулах саналтай байна.

Б.Долгор: За тэгвэл Б.Батболд, Б.Ганхүлэг нарыг нэмж оруулаад үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг батлава. Тэгэхээр үнэлгээний хорооны гишүүн бол их өндөр хариуцлагатай ажил. Эдгээр гишүүд маань хариуцлагаа их сайн ухамсарлаж ажиллах ёстой шүү.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталж, ажлын явц үр дүнд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгорт даалгав.

За ингээд хэлэлцэх асуудлаа дуусгая. Та бүхэнд баярлалаа.

Ажлын хэсгийн хурал 16 цаг 30 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч

Б.Долгор

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн

Б.Дэлгэрмаа